Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын
2026 оны ... дугаар сарын ... -ны өдрийн
... дугаар албан бичгийн хавсралт

УСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт
1	4.6.Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн усны нөөцийн зөвлөлийг байгуулж, дүрэм, бүрэлдэхүүнийг батална.	“Усны нөөцийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/753 дугаар тушаалаар шинэчлэн батлан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.
2	4.8.Сав газрын менежментийн төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Сав газрын захиргаад байгуулах тухай” Засгийн газрын 2012 оны 254 дүгээр тогтоолоор Монгол Улсын хэмжээнд 29 сав газартай байх бөгөөд 29 Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.
3	4.10.Энэ хуулийн 10.1.2-т заасан сав газар нь сав газрын захиргаатай байх бөгөөд сав газрын захиргааг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.	“Сав газрын захиргаадын бүтэц, орон тооны хязгаар болон байршлыг шинэчлэн тогтоох тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/685 дугаар тушаалаар шинэчлэн баталж, удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.
4	4.11.Усны нөөц нь экологи-эдийн засгийн үнэлгээтэй байна.	“Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлж байна.
5	5.2.Тодорхой бүс нутгийн гидрогеологийн болон гидрологийн хайгуул судалгаа, улсын зэрэглэлтэй хот, бусад хот, тосгон, суурин газрын ус хангамжийн эх үүсвэрийн хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргаж, улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.	Хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд МУ-ын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд гидрогеологийн дунд масштабын зураглал хийх, хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж нөөцийг тогтоож, баталгаажуулах тухай тусгасан байдаг. Гидрогеологийн 1:200’000-ны дунд масштабын зураглалын ажлыг Монгол орны нутаг дэвсгэрийн нийт 17.8 хувьд хийсэн байна. Гэвч сүүлийн 2 жилийн хугацаанд ажил гүйцэтгэх төсөв батлагдаагүй байна. Жил бүр улсын төсөвт 5 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох хайгуул, судалгааны ажлын зардлыг төлөвлөдөг. Гэвч сүүлийн жилүүдэд зөвхөн 1 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн хайгуулын төсөв батлагдаж байгаа бөгөөд зарим жилүүдэд огт төсөв батлагдахгүй байна. Манай улс хот, суурин газрын хүн амын унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн дийлэнх хувийг газрын доорх усаар хангадаг бөгөөд өнөөгийн байдлаар нийслэл, 21 аймгийн төв болон 75 сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоон ашиглаж байна. Цаашид 250 гаруй сумын төвийн хүн амын унд, ахуйн ус хангамжид ашиглах газрын доорх усны хайгуул, судалгааны ажлыг хийх шаардлагатай байна. Үүнээс ундны усны чанарын шаардлага хангаагүй эх үүсвэрээс ус авч буй 57 сумын төвийн ус хангамжийн асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх зорилгоор эрэл, хайгуулын ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

6	5.3.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны эх үүсвэрийн хайгуул, судалгаа явуулах шийдвэрийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргах бөгөөд энэ ажлыг захиалагч өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.	Аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгө оруулалтаар нийт 135 хайгуул, судалгааны ажил гүйцэтгэж 95 газрын доорх усны ордын нийлбэр нөөцийг 7,807.29 л/сек батлуулсан. Үүнд: Баян-Өлгий аймагт 1, Баянхонгор аймагт 6, Булган аймагт 3, Говь-Алтай аймагт 4, Говьсүмбэр аймагт 4, Дархан-Уул аймагт 2, Дорноговь аймагт 17, Дорнод аймагт 7, Дундговь аймагт 6, Өмнөговь аймагт 19, Сүхбаатар аймагт 7, Сэлэнгэ аймагт 3, Төв аймагт 8, Ховд аймагт 2, Хөвсгөл аймагт 1, Хэнтий аймагт 5 үйлдвэрлэлийн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны ордын хайгуул судалгааны ажлыг батлагдсан ажлын даалгаврын дагуу хяналт тавих ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.
7	6.1.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулна.	Газрын доорх усны нэгдсэн сүлжээ www.groundwater.mn цахим хаягийг хөтөлж мэдээллийн баазыг бэхжүүлэх ажил үргэлжилж байна. Монгол орны 21 аймгийн 81 сум, Улаанбаатар хотын 9 дүүргийг хамарсан 344 цэг ажиллаж байна. -Бүрэн автомат-89 -Хагас автомат-253 -Гар хэмжилт-2 Улсын усны нэгдсэн сүлжээнд холбогдсон цэгүүдэд суурилуулсан хэмжилтийн багаж, төхөөрөмжийг шинэчилэх, хэвийн ажиллагааг хангах, гэмтэл, засварыг хийх зардлыг шийдвэрлэх тулгамдсан асуудал байна. Тухайлбал, хагас автомат 80, бүрэн автомат 13 цэгийг засварлах шаардлагатай байна.
8	6.2.Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ байнгын ажиллагаатай дараах хэсгээс бүрдэнэ. 6.2.1.улсын хяналт-шинжилгээний сүлжээ; 6.2.2.сав газрын хяналт-шинжилгээний нэгж; 6.2.3.аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын цэг.	Улсын усны хяналт шинжилгээний сүлжээг Усны газарт нэгдсэн байдлаар хариуцсан ажиллаж, улсын хэмжээнд 344 улсын хяналт-шинжилгээний цэгээр хяналт тавин ажиллаж байна. 6.2.2 дугаар заалтын дагуу 21 сав газрын захиргаанаас хяналт-шинжилгээний нэгжийг хариуцан ажиллаж, нийт 255 хяналт шинжилгээний цэгээр хяналт шинжилгээг хэрэгжүүлж байна. 6.2.3 заалтын хүрээнд томоохон аж ахуйн нэгжүүд дотоод хяналтын цэгийг ажиллуулж байгаа бөгөөд Усны газарт тайлан мэдэллийг ирүүлдэг. Гэвч 2026 онд Улсын усны нэгдсэн сүлжээг өргөжүүлэх ажилд төсөв батлагдаагүй тул орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр ус ашиглагч аж ахуйн нэгж, байгууллагад дотоодын хяналтын цэг байгуулж, сүлжээнд холбох тухай зөвлөмж хүргүүлсэн. Үр дүнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 1 автомат, 1 бүрэн автомат, 1 засвар багаж шинээр суурилуулсан. Үүнд: - Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сум /хяналт, хагас автомат/ - Баянхонгор аймгийн Баян-Овоо сум /хяналт, бүрэн автомат/ - Сүхбаатар аймгийн Сүхбаатар сум /хяналт, засвар/ Мөн Монголын мянганы сорилтын сангийн санхүүжилтээр Туул голын сав газарт хамаарах 61 газрын доорх усны хяналт-шинжилгээний цэгүүдийдэд газар дээр нь цэгийн тулгалт, сонголт хийж ажиллан засварлаж багаж тоног төхөөрөмж суурилуулах ажлын бэлтгэл хангагдаад байна. 2026 оны 2-р улиралд багтаан багаж тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэж Усны газарт хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Цаашид тус сүлжээг улсын хэмжээнд багадаа 700 цэг болгох

		хэрэгцээ шаардлага байгаа тул төсөв хөрөнгийн асуудлыг шийвэрлэх шаардлагатай, мөн хурдан шуурхай мэдээлэл дамжуулах хүрээнд улсын усны хяналт шинжилгээний сүлжээг онлайн цэгээр өргөжүүлж, удирдлагын системийг шинэчилэн сайжруулах хэрэгтэй.
9	7.2.Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Журам батлах тухай” Байгаль орчны сайдын 2006 оны А/269 дүгээр тушаалаар “Усны тоо бүртгэл явуулах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
10	7.3.Усны тоо бүртгэлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулна.	Улсын усны тоо бүртгэлийг аймаг, сум, нийслэл, дүүргийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга жил бүр зохион байгуулж, улсын усны мэдээллийн санд оруулан ажиллаж байна.
11	7.4.Усны мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн улсын усны төлөв байдлын тайланг жил бүр усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гаргана.	Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/527 дугаар тушаалын дагуу жил бүр мэдээллийг нэгтгэж гаргаж байна.
12	10.1.2.Монгол Улсын гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарилалт байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн сав газрыг байгуулж, сав газрын захиргааны бүтэц, зохион байгуулалтыг батлах;	“Сав газрын захиргаадын бүтэц, орон тооны хязгаар болон байршлыг шинэчлэн тогтоох тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/685 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан.
13	10.1.3.усны нөөцийг тооцоолох, усны тоо бүртгэл явуулах, усны нөөцийн экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоох, усны хэрэглээний норм тогтоох, усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх, усны сан бүхий газрыг нөхөн сэргээх, уст цэг, усны барилга байгууламжийг ашиглах, эзэмших, ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам, зааврыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлах;	“Журам батлах тухай” Байгаль орчны сайдын 2006 оны А/269 дүгээр тушаалаар “Усны тоо бүртгэл явуулах журам”-ыг, “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор, “Журам батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/156 дугаар тушаалаар “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
14	10.1.4.сав газрын менежментийн төлөвлөгөөний аргачилсан зааврыг боловсруулж батлах;	“Аргачлал батлах тухай” Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2023 оны А/626 дугаар тушаалаар Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний аргачлал, арга хэмжээний төлөвлөгөөний бүтцийн маягт, хэрэгжилтийн хяналт шинжилгээний үнэлгээний маягтыг батлан хэрэгжүүлж байна.
15	10.1.5.усны хайгуул, судалгаа хийх мэргэжлийн байгууллагын эрх олгох, цуцлах;	Усны мэргэжлийн байгууллагын эрх олгох, сунгах эрхийг (2024-2026 онд) 124 аж ахуйн нэгж байгууллагад олгосон байна.
16	10.1.6.усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлал батлах;	“Аргачлал батлах тухай” Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2020 оны А/59 дүгээр тушаалаар Усны нөөцөд учирсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох аргачлалыг батлан хэрэгжүүлж байна.
17	10.1.7.хилийн усны талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх;	“Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан 2025 оны А/74, А/10 дугаар хамтарсан тушаалаар Монгол, Хятадын хилийн усны хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүн, Монгол, Оросын хилийн усны хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулан ажиллаж байна.

18	10.1.8.голын голдирлыг өөрчлөх асуудлаар шийдвэр гаргах;	“Голын голдирлыг өөрчлөх тухай” Багаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/260 дугаар тушаал, “Голын голдирлыг түр өөрчлөх тухай” Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны А/552 дугаар тушаалыг батлан хэрэгжүүлсэн.
19	10.1.10.эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам батлах;	“Журам шинэчлэн батлах тухай” Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2019 оны А/301/265 дугаар тушаалаар “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
20	10.1.12.ус бохирдуулах аюултай бодисын жагсаалтыг батлах;	“Жагсаалт батлах тухай” Байгаль орчин, аялал жуучлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/301/265 дугаар тушаалаар “Рашааныг зохистой ашиглах, хамгаалах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.
21	10.1.28.гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усны сан бүхий газарт ус, усан орчинтой холбоотой шинжилгээ, судалгаа явуулах эсэх талаар шийдвэр гаргах;	“Зөвшөөрөл олгох тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2026 оны А/220 дугаар тушаалаар Монгол Улсын Их Сургуулийн эрдэмтдийн судалгааны багт зөвшөөрлийг олгосон.
22	16^1.2.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана;	Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг шинээр гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, эрх зүйн баримт бичгийн шинэчлэлтийн талаар сургалт зохион байгуулж, вэб сайт, цахим системээр дамжуулан түргэн шуурхай хүргэж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Үүнд: 2023 онд нийт 2 удаагийн сургалтаар 78 хүн, 2024 онд нийт 3 удаагийн сургалтаар 122 хүн, 2025 онд 2 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 108 хүн, ус ашиглагч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг тухай бүр мэдээ, мэдээллээр ханган ажилласан. Усны газар нь усны нөөцийг зүй зохистой ашиглах, гадаргын усыг хуримтлуулах замаар ус хангамжийг нэмэгдүүлэх, үер усны аюул болон усны хомсдлоос урьдчилан сэргийлэх, мөн ус бохирдуулах, хомсдуулах эрсдэлийг бууруулах чиглэлээр 5 төрлийн видео контент бэлтгэж, Усны газрын AI туслах Мөрөнгол (MG)-ээр дамжуулан цахим системээр олон нийтэд хүргэн ажилласан. Ус ашиглуулах дүгнэлт гаргах хүсэлтийг Ewater.mn цахим системээр 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөс хойш нийт давхардсан тоогоор 1065 хүсэлтийг хүлээн авч, баримт бичгийн шаардлага хангасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж байна.
23	16^1.3. Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана;	Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны газар, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг шинээр гарсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, эрх зүйн баримт бичгийн шинэчлэлт, ewater.mn цахим системийг хэрхэн ашиглах зэрэг холбогдох мэдээ, мэдээллийг нэгдсэн хурал, семинар, зөвлөгөөн зохион байгуулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. 2023 онд нийт 2 удаагийн сургалтаар 78 хүн, 2024 онд нийт 3 удаагийн сургалтаар 122 хүн, 2025 онд 2 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 108 хүн хамруулсан байна.
24	16^1.4.1.улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах	2013-2021 хэрэгжүүлсэн улсын УННМТ-ний хэрэгжилтийн үр дүнг тооцоход 71 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн. 2023-2033 онд хэрэгжүүлэх "Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”-г 4 зорилго, 19 зорилт, 76 арга хэмжээ, ажиллагаатайгаар төлөвлөж 2022 онд боловсруулан, холбогдогч талуудаар үе шатны хэлэлцүүлгүүдийг хийж, үнэлгээг гаргасан. Улсын усны нөөцийн нэгдсэн

		менежментийн төлөвлөгөөг одоог хүртэл батлагдаагүй байгаа нь салбар хоорондын уялдаа холбоог хангаж чадахгүй нөхцөл үүсэж байгаа нь тулгамдсан асуудал болоод байна. Тус менежментийн төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж уялдаж ажиллах талаар холбогдох төр захиргааны байгууллагууд, төрийн бус байгууллагууд болон сав газрын захиргаадыг чадавхижуулах сургалтуудыг зохион байгуулсан.
25	16^1.4.2.усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар байгуулагдсанаас хойш нийт 85 ажлын даалгавар усны газраар баталгаажуулсан. Үүний 30 ажлын даалгаврын дагууд үр дүнг Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж нөөцийг баталгаажуулсан бол 7 ажлын даалгаврыг шинэчлэн батлуулах, 6 ажлын даалгаврыг нөөц батлахгүй шийдвэрт хүрэх, санхүүжилтээс шалтгаалан 6 ажлын даалгавар түр зогссон бөгөөд бусад батлагдсан ажлын даалгаврын дагууд ажил үргэлжилж байна. Батлагдсан ажлын даалгаврууудыг чиг үүргээр нь ангилахад: -Цэнхэрийн халуун рашаан, Хульжийн рашаан, Оргилын нүүрс хүчилт-хүйтэн рашаан, Бага шаргалжуутын рашаан, Цагаан сүмийн халуун рашаан - Шинэ Хархорум хот, Баганаар дүүрэг, Булган аймгийн Дашинчилэн сум, Өвөрхангай аймгийн Хайрхандулаан, Төгрөг, Уянга, Бат-Өлзий сумд, Говь-Алтай аймгийн Төгрөг, Халиун, Дундговь аймгийн Адаацаг, Эрдэнэдалай сум, Дорноговь Дэлгэрэх, Өмнөговь аймгийн Даланзадгад, Баян-Овоо, Сэврэй, Манлай, Ханхонгор, Цогт-Овоо, сумын төв, Ханги, Цагаан хад сууршлын бүсийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын даалгавар; - Салхитын мөнгөний орд, Оюутолгой алт зэсийн орд, Тэнэгэр говь нүүрс баяжуулах үйлдвэр, Баянхөндийн алтны үндсэн орд, Хармагтайн алт зэсийн үндсэн орд, Халзанбүрэгтэй газрын ховор элементийн орд, Энгэр сухайт зэсийн орд, Цагаан суварга зэсийн орд, Хуурай тал нүүрсний орд, Арын нуур молибдений орд, Цахир толгой алт зэсийн орд, Наран жонш баяжуулах үйлдвэр, Хонгор Овоо хайлуур жонш, Чигэртэй алт зэсийн орд, Салхитын бор толгой цайрын орд, технологийн ус хангамж болон уурхайчдын тосгоны хүн амын унд, ахуйн ус хангамжийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын ажлын даалгавар; - Гидрогеологийн судалгаа, Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгаа, Гидрогеологийн дунд масштабтай зураглалын ажил - Дамбадаржаа дэд төвийн дулааны цахилгаан станц, Алтанширээ сумын нутаг дахь 300МВ дулааны цахилгаан станц, Тавантолгой 450 МВ дулааны цахилгаан станц, Шарын гол дулааны станц, Дорнод 50 МВ дулааны цахилгаан станц, Тосонцэнгэл 18 МВ дулааны цахилгаан станц, Гашууны талд байгуулах 660 МВт-ийн цогцолбор, Мандах сумын 100 МВ дулааны цахилгаан станц, Хөшөөт 100 МВ дулааны цахилгаан станцын технологийн ус хангамжийн шинэ эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын даалгавар; - Мэт Агро тариалангийн талбай, М Агро тариалангийн талбай, Газпровод союз восток хий дамжуулах хоолой, Орхон аймгийн Газрын тос дамжуулах төсөл, Сүхбаатар аймгийн Газрын тос дамжуулах хоолой төсөл, Алтанширээ аж үйлдвэрийн

		цогцолбор төслүүдийн ус хангамжийн нөөцийг тогтоох эрэл хайгуулын судалгааны ажлын хээрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил аргазүйн зөвлөмж өгч ажилласан.
26	16[1].4.3.усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих	Усны тухай хууль батлагдсанаас хойш 29 сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Монгол Улсын Усны нөөцийн зөвлөлийн хурлаар усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулсан. Усны нөөцийн зөвлөлийн хурлын үр дүнг үндэслэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын тушаалаар Туул, Хөвсгөл-Эг, Улз, Хэрлэн, Хар нуур-Ховд гол сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг батлуулсан. “Усны тухай” хуулийн 16[1].4.10 дахь заалтыг үндэслэн 2025 оны жилийн эцсийн байдлаар усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар 286 ААНБ-аас хүсэлт ирүүлснээс дүгнэлт гаргах боломжгүй засварлаж дахин хандуулахаар зөвлөмж өгсөн 61 төсөл, дүгнэлт гаргах боломжгүй татгалзсан 81 төсөлд холбогдох хариуг цахимаар хүргүүлж, 119 ААНБ-д дүгнэлт гаргасан. Үүнд: • Барилга, дэд бүтэц – 10 • Амралт, сувилал, аялал жуулчлал – 18 • Уул уурхай – 49 • Агуулах, гаалийн хяналтын талбай – 9 • Хөнгөн үйлдвэр – 20 • Усаар хангагч байгууллага – 5 • Хүнд үйлдвэр – 8 Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний мэргэжлийн зөвлөлийн хуралд устай холбоотой асуудлаар тухай бүрд санал өгч ажилласан.
27	16[1].4.4.энэ хуулийн 4.9-д заасан ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг тогтоох санал боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих	Монгол орны хэмжээнд 2025 оны байдлаар Усны нөөцийн зөвлөлийн хурлаар нийт 427 тайланг хэлэлцүүлж 245 газрын доорх усны ордын нийлбэр нөөцийг 20,343.05 л/сек-ээр баталгаажуулан хүлээн авсан. Үүнээс хүн амын унд, ахуйн зориулалттай газрын доорх усны 107 ордын нийлбэр нөөцийг 8,906.96л/сек, үйлдвэрлэлийн ус хангамжийн эх үүсврийн зориулалттай газрын доорх усны 138 ордын нийлбэр нөөцийг 11,436.09 л/сек-ээр тус тус хүлээн авсан. 2025.05.20-ны өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хурлаар 4 усны сав газрын менежментий төлөвлөгөө, 3 усны сав газрын төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулах төлөвлөгөөг хэлэлцүүлсэн. 2025.07.25-ны өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хурлаар 3 асуудлыг хэлэлцүүлж “Шинэ хархорум хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэр”, Гэрэлт говь нэртэй үйлдвэрлэл технологийн паркийн ус хангамжийн хэрэгцээг хангах газрын доорх усны эрэл хайгуулын тайлан, Шинэ хархорум хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэр тогтоох газрын доорх усны эрэл хайгуулын тайлан, Усны Мега төслүүдийг талаарх төрөөс барих бодлогын асуудлуудыг хэлэлцсэн.

		Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны А/753 дугаар тушаалаар Усны нөөцийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүн шинэчлэн батлагдсан. 2025.11.11-ны өдрийн Усны нөөцийн зөвлөлийн хурлаар Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах ажлын 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэх ажил"-ын тайлан, Дорноговь аймгийн Мандах сумын нутаг дахь "Нарангийн хоолой-2" нэртэй талбайд Цагаан суваргын зэс-молибдены үйлдвэрийн технологийн усан хангамжийн нэмэлт эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын тайлан, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын төвийн ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын тайлан, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын нутагт баригдах Чигэртэй алт-зэс-кобальтын баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын тайлан, нэртэй газарт орших хайлуур жоншны уурхайн баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн эх үүсвэрийн зориулалтаар явуулах газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын тайлан, "М-Агро" ХХК-ийн ус ашиглалтаас Мөрөн голын экологийн урсац болон төслийн талбайн газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг тогтоох ажил. Тус ажлын үр дүнд үндэслэн БОАЖЯ-ны ТНБД-ын 2023 оны А/03 дугаар тушаалаар Мөрөн голын газрын доорх усны ордын 7.26 л/сек-ээр батлагдсан нөөцийг нэмэгдүүлэх боломжтой эсэхэд санал авах танилцуулгыг хэлэлцүүлсэн.
28	16^{1}.4.5.улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдалтай холбоотой мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг хангах	Улсын усны мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх, усны төлөв байдалтай холбоотой мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг шуурхай, үнэн зөв мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд 2025-2026 онд дараах ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Улсын усны мэдээллийн сангийн 2025 оны алдаа, зөрүүтэй мэдээлэлд хяналт, баталгаажуулалтын ажлыг зохион байгуулж, зөрүүтэй болон давхардсан тоон мэдээллийг засварласан. Мөн Улсын усны мэдээллийн сангийн 2025 оны нэгтгэл тайланг холбогдох журмын дагуу боловсруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд хуулийн хугацаанд цахимаар болон маягтаар хүргүүлсэн. Аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудаас ирүүлсэн БОХ 2.1, БОХ 2.2 маягтын мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн хүлээн авч, хянан баталгаажуулж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд оруулсан. Тус ажлын гүйцэтгэл 100 хувь хангагдсан бөгөөд орон нутгийн мэдээлэл бүрдүүлэлт, тайлагналын хариуцлага сайжирсан. Усны мэдээллийг цахимжуулах, нэгдсэн системд шилжүүлэх зорилтын хүрээнд улсын усны нэгдсэн платформ болох infowater.mn системийн хэвийн үйл ажиллагааг хангах, зүгшрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг 2025 оноос эхлэн зохион байгуулсан. Усны тоо бүртгэл, хяналт-шинжилгээний мэдээллийг тус системд үе шаттайгаар оруулж эхэлсэн нь мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх алхам болсон. Системийн хэрэглээг нэмэгдүүлэх, оролцогч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр “Улсын усны мэдээллийн систем”-ийг ашиглах сургалтыг зохион байгуулсан. Системийн ашиглалтын явцад гарч буй хүндрэл,

		техникийн алдаа, хөгжүүлэлтийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор сав газрын захиргаад болон хэрэглэгч байгууллагуудаас санал авч, нэгтгэн системийг хөгжүүлэгч “Эрхэт инноваци” ХХК-д албан ёсоор хүргүүлсэн. Үүний дагуу холбогдох мэргэжилтнүүдийн уулзалтыг зохион байгуулж, системийн сайжруулалт, алдаа засварын ажлыг эрчимжүүлэн, тодорхой хугацаанд гүйцэтгүүлэхээр тохиролцон хэрэгжилтийг хангуулсан. Улсын усны мэдээллийн сангаас 2025 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нийт 25, 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 23 хүсэлт, лавлагааны дагуу холбогдох мэдээллийг гаргаж, хууль тогтоомжийн хүрээнд хариу, мэдээлэл өгсөн байна.
29	16[1].4.6.улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, усны нөөц, ус ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах	Улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах, усны нөөц, ус ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах чиг үүргийн хүрээнд 2025–2026 онд мэдээлэл бүрдүүлэлт, хяналт, нэгтгэлийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газруудаас БОХ 2.1, БОХ 2.2 маягтын дагуу ирүүлсэн усны тоо бүртгэл, ашиглалтын мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн хүлээн авч, хянан баталгаажуулж, байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд оруулсан. Ингэснээр улсын хэмжээнд усны нөөц, ашиглалтын статистик мэдээллийг жигд стандартын дагуу бүрдүүлэх нөхцөл бүрдсэн. Монгол орны усны тоо бүртгэлийн 2025 оны дүн мэдээгээр: Нуур, тойром – 4,739 Гол, мөрөн –6,932 Булаг, шанд – 15,191 Рашаан – 646 Усан сан, хөв цөөрөм – 350 Худаг – 81,337 дүгнэгдсэн нь улсын усны нөөцийн бүртгэл, мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлж байна. Усны нөөцийн төлөв байдлын өөрчлөлтийн хувьд 2025 онд нийт 499 гадаргын ус (гол горхи 97, нуур тойром 94, булаг шанд 307, рашаан 1) сэргэсэн бол 220 гадаргын ус (гол горхи 2, нуур тойром 64, булаг шанд 152, рашаан 2) хатаж ширгэсэн үзүүлэлттэй байна. Мөн нийт 21 аймаг, нийслэлийн Байгаль орчны газруудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллаж, усны тоо бүртгэл, статистик мэдээллийг нэгтгэн боловсруулах чадавхыг сайжруулсан.
30	16[1].4.7.усны экологи-эдийн засгийн үнэлгээ, усны үнэ, тариф тогтоох чиглэлээр судалгаа хийх аргачлал, зааврыг боловсруулах, усны нөөцөд учруулсан хохирлыг тооцох	Усны нөөцийн эдийн засгийн үнэлгээ, усны үнэ тарифыг боловсронгуй болгох чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран судалгаа, шинжилгээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2030 Water Resources Group-ийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар Монгол Улсын Засгийн газрын холбогдох байгууллагуудтай хамтран 2018–2019 онд Улаанбаатар хотын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний үнэ тарифын тогтолцоо, зардал нөхөх чадамж, хэрэглэгчийн төлбөрийн чадварт үнэлгээ хийсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022

		оны 416 дугаар тогтоолоор 2013 оны 326 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулж, ус их хэрэглэдэг салбарууд болох архи, пиво, согтууруулах ундааны үйлдвэрлэл болон ашигт малтмал олборлох, баяжуулах, зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах үйл ажиллагаанд ногдуулах усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг гадаргын усанд 10-25 хувь, газрын доорх усанд 20-35 хувь болгон нэмэгдүүлж, мөн усны нөөц ашигласны төлбөрийн хөнгөлөлтийн хувь хэмжээг шинэчлэн 100 хувь болгох, хаягдал ус цэвэрлэж, эргүүлэн ашиглах зохицуулалтыг тодотгон тусгасан. Мянганы Сорилтын сангийн Монгол Улсад хэрэгжүүлсэн ус хангамж, ариутгах татуургын төслийн хэрэгжилтийн эцсийн тайланд усны үйлчилгээний үнэ тариф нь зардал нөхөх түвшинд хүрээгүй бөгөөд цаашид тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлж зардал нөхөх зарчимд ойртуулах, хэрэглээний шаталсан тарифын тогтолцоо нэвтрүүлэх, мөн нийгмийн эмзэг бүлгийн хамгааллыг харгалзан үзэх шаардлагатай гэж дүгнэснийг үндэслэн усны үнэ тарифын шинэчлэлийн бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Усны газар болон Ус сувгийн удирдах газар зэрэг холбогдох байгууллагуудаас тарифыг үе шаттай нэмэгдүүлэх, зардал нөхөх зарчимд ойртуулах, шаталсан тарифын тогтолцоо нэвтрүүлэх, нийгмийн эмзэг бүлгийн хамгааллыг харгалзан үзэх чиглэлээр арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Усны нөөцөд учруулсан хохирлыг тооцох чиг үүргийн хүрээнд 2025–2026 онд шинжээчийн дүгнэлтийн ажлыг холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлэн ажилласан. 2025 онд ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан 47 зөрчлийн хэрэгт шинжээчээр ажиллаж, усны нөөцөд учруулсан хохирлыг урьдчилсан байдлаар нийт 3,671,656,700 төгрөгөөр тооцон, нөхөн төлбөрийг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэхээр холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн. 2026 оны эхний улирлын байдлаар ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан 2 хэрэгт шинжээчээр ажиллаж, усны нөөцөд учруулсан хохирлыг урьдчилсан байдлаар 109,385,034 төгрөгөөр тооцон, нөхөн төлбөр ногдуулах санал, дүгнэлтийг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Мөн өмнөх оны 1 дүгнэлтэд шүүхийн шийдвэрийн дагуу дахин шинжилгээ хийсэн. Тус тохиолдолд ус ашиглалтын тоолуурын заалтын зөрүүтэй байдлаас шалтгаалан өмнө нь тогтоосон 583,688,160 төгрөгийн актыг хүчингүй болгож, дахин нарийвчилсан тооцоо хийсний үндсэн дээр 386,249,720 төгрөгийн нөхөн төлбөр, хохирлыг шинэчлэн тогтоож, эрх бүхий улсын байцаагчид хүргүүлсэн.
31	16^{1}.4.9. Энэ хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан ус ашиглах дүгнэлт, 28.6-д заасан ус ашиглах зөвшөөрөл, 28.11-д заасан гэрээнд хяналт тавих;	Усны газар нь хоногт 100 шоометрээс дээш ус ашиглагч аж ахуйн нэгжид дүгнэлт гаргахаас гадна Сав газрын захиргаад, аймаг, нийслэлийн Байгаль орчны газраас гаргасан ус ашиглуулах дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлд, хагас, бүтэн жилээр хяналт тавьж, тоон мэдээллийг нэгтгэн, мөн ус ашиглуулах дүгнэлт боловсруулах бүрд урд оны дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлд тухай бүр хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилладаг. 2025 оны байдлаар СГЗ-аас нийт 163 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр ногдуулсан усны хэмжээ 1,2 сая.$м^3$/жил, урьдчилсан байдлаар

		ногдуулсан төлбөр 305.7 сая төгрөг, аймаг, нийслэлийн БОГ-аас нийт 459 ус ашиглуулах дүгнэлт гаргаж, ногдуулсан усны хэмжээ 2.1 сая.м^3/жил урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр 414.1 сая.төгрөг байна.
32	16^1.4.10. Голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах;	Голын голдирлыг өөрчлөх, урсацад тохируулга хийх, шилжүүлэн ашиглахаар 2024 онд “Хэнтий аймгийн Чингис хотыг тойрон гаргах 14,42 км автозам болон шинээр барих гүүрний инженерийн нарийвчилсан зураг төсөл”-ийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын 3-р багийн нутагт Хэрлэн гол дээр хийгдэх 265.72 у/м төмөрбетон гүүрийг барихтай холбогдуулан Хэрлэн голын голдирлыг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 11 дүгээр сарын 01-ийг хүртэл түр хугацаагаар өөрчлөх боломжтой талаар дүгнэлт гаргасан. Усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. 2023 онд 18 зураг төсөлд, 2024 онд 9 зураг төсөл, 2025 онд нийт 16 зураг төсөл дүгнэлт гаргасан байна.
33	16^1.4.11.стратегийн томоохон орд газарт цооног өрөмдөх, ус ашиглах судалгаа хийхэд дүгнэлт гаргах	Усны тухай хууль батлагдсанаас хойш стратегийн орд газруудад газрын доорх усны цооног өрөмдөх байршлыг, багаж тоног төхөөрөмж суурилуулж Улсын усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээнд холбон газрын доорх усны түвшин, усны даралт, агаарын даралт, усны температур, агаарын температур, цахилгаан дамжуулах чадварын мэдээллийн 6 цагийн интервалтай хүлээн авч боловсруулан ажиллаж байна. Дараах стратегийн орд газруудад газрын доорх усны хяналт шинжилгээний цэг байгуулан ажиллаж байна. Үүнд: Тавантолгой бүлэг нүүрсний орд газарт 10 цэг, Нарийнсухайт нүүрсний орд 7 цэг, Багануур хүрэн нүүрсний орд 1 цэг, Шивээ-Овоо хүрэн нүүрсний орд 4 цэг, Оюутолгой зэс молибдений орд 13 цэг, Цагаан суварга зэс молибдений орд 2 цэг, Эрдэнэт зэс молибдений орд 4 цэг, Төмөртэйн Овоо цайр хар тугалгын орд 1 цэгийг байршуулан газрын доорх усны өөрчлөлтөд хяналт тавьж ажиллаж байна.
34	16^1.4.12. Ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөц хомсдох, бохирдсон тохиолдолд тухайн сав газарт ус ашиглагчийн ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчныг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох;	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А/66 тушаалаар “Ган, цөлжилт, хуурайшилтын зэрэглэл тогтоох болон энэ үед мөрдөх усны нөөцийн менежментийн журам”-ыг батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус журмын хүрээнд Баянхонгор аймгийн Гурван булаг суманд төсөл хэрэгжүүлэгч “Жи энд юу голд” ХХК-ийн үйл ажиллагаанаас шалтгаалж Шар усны гол татарч, голоос ундаалж буй 2400 гаруй малчид ундны усгүй болох нөхцөл үүсээд байсан тул Усны газраас гаргасан Ус ашиглуулах дүгнэлтийн дагуу Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа гэрээ байгуулахдаа Шар усны гол бүрэн дүүрсэн тохиолдолд ус татах нөхцөл заасан байна. Аварга тосон нуурыг бохирдол, ширгэхээс хамгаалах, байгалийн унаган төрхийг сэргээх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор Хэнтий аймгийн ИТХ-ын шийдвэрээр тус нуурыг 3 жилийн хугацаанд (2022–2024 он) түр ашиглуулахыг хориглосон бөгөөд уг шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажилласан. анга, Өгий нуурыг бохирдол, ширгэлт, элсний нүүлтээс хамгаалах, урсацыг сайжруулах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх зорилгоор 2024–2025 онд Ерөнхийлөгчийн санаачилгаар ойн зурвас байгуулах, хамгаалалтын хашаа барих

		зэрэг ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Мөн нуур сэргээх “Монгол загвар”-ыг Ганга нууранд нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.
35	16[1].4.13. Бэлчээрийн усжуулалт, услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах;	2025 онд “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” L3895/L3896/G9205 төслийн хүрээнд боловсруулсан: “Төв аймгийн Борнуур сумын 970 га Борнуурын услалтын системийн засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөлд дүгнэлт гарган хүргүүлсэн. Шифр: HDP-04/2025 2026 онд Хэнтий аймгийн мөрөн сумын Эрдэнэ-Уул услалтын системийн засвар шинэчлэлтийн ажлын зураг төсөл Шифр HDP-07/2025 Дархан-Уул аймгийн Орхон сумын 79-н услалтын системийг сэргээн засварлах, өргөтгөл, шинэчлэлт хийх ажлын зураг Шифр HDP-09/2025
36	16[1].4.14.бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулах	Бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд тус ажлын хэсэгт Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, усны мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулахаар бэлтгэл ажлыг хангасан.
37	16[1].4.15.хуульд заасан бусад бүрэн эрх.	Усны газрын даргын 2025 оны А/170 дугаар тушаалаар баталсан “Булгийн эхийг хашиж хамгаалах жишиг зааврыг батлах тухай” зааврын дагуу Усны нөөцийг бохирдох, хомстохоос сэргийлэх зорилгоор булаг шанд, рашааны эхийг хашиж, хамгаалах ажлыг орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн хөрөнгөөр 2025 онд нийт 162 булаг шандын эхийг хашиж хамгаалж тохижуулсан. Усны газрын даргын 2025 оны А/169 дугаар тушаалаар баталсан “Усны сан бүхий газар, усны эх Үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийг зураглах аргачилсан заавар батлах тухай” зааврын дагуу 2025 оны байдлаар нийслэл болон 13 аймаг усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг зураглаж аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Бусад аймгууд хамгаалалтын бүсийн зураглалын ажлыг бүрэн гүйцэт зураглаж дууссан.
38	Усны тухай хуулийн 11.1.4, 22.5. 22.4. 22.5 заалтуудын биелэлтийг аймгаар гаргах	Усны газрын даргын 2025.11.14-ний өдрийн А/169 дугаарт тушаалаар “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийг зураглах аргачилсан заавар”-ыг батлуулсан. 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол орны хэмжээнд дараах Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн хилийг батлуулсан. Үүнд: 1. Говь-Алтай аймгийн ИТХ-ын 2022.06.13-ны өдрийн 22 дугаар тогтоол, 2. Говьсүмбэр аймгийн ИТХ-ын 2024.07.24-ний өдрийн 05 дугаар тогтоол, 3. Дундговь аймгийн ИТХ-ын 2022.04.13-ны өдрийн 27 дугаар тогтоол, 4. Завхан аймгийн ИТХ-ын 2019.12.02-ны өдрийн 54 дугаар тогтоол, 5. Орхон аймгийн ИТХ-ын 2025.12.03-ны өдрийн 02/55 дугаар тогтоол, 6. Өмнөговь аймгийн ИТХ-ын 2024.09.18-ны өдрийн 19/23 дугаар тогтоол, 7. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 223.03.31-ний өдрийн 02 дугаар тогтоол,

		8. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2024.04.02-ны өдрийн 155 дугаар тогтоол, 9. Увс аймгийн ИТХ-ын 2025.06.13-ны өдрийн 36 дугаар тогтоол, 10. Ховд аймгийн ИТХ-ын 2018.12.02-ны өдрийн 8/11 дугаар тогтоол, 11. Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2025.12.05-ны өдрийн 90 дугаар тогтоол, 12. Хэнтий аймгийн ИТХ-ын 2020.04.08-ны өдрийн 05 дугаар тогтоол 13. Нийслэлийн ИТХ-ын 2024.06.13-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор тус тус усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоосон.
39	16^1.2. Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, дагалдан гарсан дүрэм, журам, аргачлал, стандартуудын талаар сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. Үүнд: 2023 онд нийт 11 удаагийн сургалтаар 391 хүн, 2024 онд нийт 11 удаагийн сургалтаар 522 хүн, 2025 онд 12 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 795 хүн хамруулсан.
40	16^1.3. Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.	
41	16^1.4.8. ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих;	-“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2011” стандартыг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2012.05.17-нд батлагдсантай холбогдуулан шинэчлэн боловсруулж, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 50 дугаар тогтоолоор “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандартыг батлуулсан. Хүрээлэн буй орчинд хаягдал ус нийлүүлж буй ус бохирдуулагчдын төлбөрийг энэхүү стандартын үзүүлэлтүүдийг үндэслэл болгон ногдуулж байна. -Монголын Мянганы Сорилтын сангийн санхүүжилтээр “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2015” стандартыг Зөвлөх үйлчилгээний Sereuca” болон Еврохан компаниар шинэчлэн боловсруулж, холбогдох эрх ашиг нь хөндөгдөх талуудаар 7 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, салбар тус бүрийн яам, агентлагууд, мэргэжлийн холбоод, томоохон ус ашиглагч байгууллагуудаас саналыг авч тусган, Стандарт, хэмжилзүйн газарт Усны газрын даргын 2024 оны 01/184 албан тоотоор хүргүүлж, Стандарт, Хэмжилзүйн газрын техникийн хороогоор 2024 оны 09 сарын 27-ны өдөр хэлэлцүүлж дэмжүүлэн, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн С/43 тоот тушаалаар "Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага" MNS 6561:2024 стандартыг батлуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдүүлэн ажиллаж байна. -Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан Мянганы сорилтын компакт гэрээний хүрээнд

		баригдаж буй Хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэрийн боловсруулсан усыг Дулааны III, IV цахилгаан станцуудад нийлүүлэхтэй холбоотой MNS6734:2018 стандартад өөрчлөлт оруулж, оролцогч талуудын саналыг тусган, Стандарт, Хэмжилзүйн газрын техникийн хороогоор хэлэлцүүлэн, Стандарт, хэмжилзүйн газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн С/13 дугаар тушаалаар “Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага MNS 6734:2025” стандартыг батлуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө”-ний VI.2, VI.8, VI.9 дэх хэсэгт тусгагдсан ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх, стандартуудыг шинэчлэх ажлууд /Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн нэмэлт өөрчлөлт, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн шинэчилсэн найруулга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны А/705, А/205 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар батлагдсан “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ”, “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024” стандарт/ хийгдсэнтэй холбогдуулан ewater.mn цахим системд хөгжүүлэлт хийх зайлшгүй шаардлага тулгарч, Мянганы Сорилтын сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Аствишн” ХХК-иар гүйцэтгүүлж, системд ажиллах албан хаагчдад сургалтыг зохион байгуулаад байна.
42	24.2. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл энэ хуулийн 10.1.12-д заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно.	Монгол Улсын Их Хурлаар Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдан, 2019 онд нэмэлт, өөрчлөлт орж, хуулийг дагалдан Засгийн газрын 1 тогтоолоор 2 эрхзүйн акт, Засгийн газрын гишүүдийн хамтарсан 3 тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 3 тушаал батлагдсанаар 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Улсын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус хуулийн 2019 оны нэмэлт өөрчлөлтөөр усны нөөцийг бага бохирдуулбал бага, их бохирдуулбал их төлөх зарчмыг баримтлан хаягдал усаа стандартад нийцүүлэн цэвэрлэж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжих асуудлыг тодорхой тусгаж өгсөн. Усны газар 2023 онд 174, 2024 онд 219, 2025 онд 252 ус бохирдуулагчид Хаягдал усны дүгнэлт гаргаж, харъяа Сав газрын захиргаанд хүргүүлсэн. Сав газрын захиргаад Усны газрын гаргасан Хаягдал усны дүгнэлтийг үндэслэн “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл”-ийг олгож ажилласан.
43	25.2. Ус бохирдуулагч нь бохирдуулах бодисыг хаягдал усны стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж, төлөлтөд хяналт тавих бөгөөд нөхөн төлбөрийн хэмжээг ус бохирдуулсны төлбөрийг хоёроос тав дахин шатлан өсгөх хэлбэрээр нэмэгдүүлж, бохирдуулах бодис бүрээр тогтооно.	-“Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943:2015” стандарт, “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024” стандартын зөвшөөрөгдөх дээд агууламжаас хэтрүүлэн гаргасан бохирдуулах бодис тус бүрээр ус бохирдуулсны нөхөн төлбөрийг ногдуулж ажилласан. Тус хуулийн заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын Усны хяналтын төв лабораторыг Хаягдал усны чанарын MNS6561:2024 стандартын 30 үзүүлэлт, MNS4943:2015 стандартын 44 үзүүлэлтийг бүрэн шинжлэх тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг Мянганы

		Сорилтын сан болон Өмнөговь аймгийн Байгаль орчны газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулж, нийт 1.7 тэрбум төгрөгийн өртөг бүхий Бохир усны хүнд металлын сорьцын шинжилгээг хүнцэл, селен, уран, рубиди, анзан, биндер, теллур гэсэн 7 үзүүлэлтээр нэмж тодорхойлдог ICPE-AOS ком багаж-1ш, хөргөгч-2ш, нүд угаагч-3ш, температур хэмжигч-4ш, органик бодис тодорхойлогч-1ш, шил сав угаагч автомат машин-1ш, сорох шүүгээ-1ш, плитка-1ш, насос-1ш, 3-тай шүүлтүүр-1ш, 6-тай шүүлтүүр-1ш, BOD инкубатор-1ш, хатаах шүүгээ-2ш, дээж бэлтгэгч-1ш, сульфид тодорхойлох багаж-1ш тус тус хүлээн авч, бохир усны химийн шинжилгээний өрөөний талбайг томсгон, суурилуулах ажлыг зохион байгуулж, 2025 оны 8 дугаар сард итгэмжлэлийг сунгуулсан.
44	25.3. Энэ хуулийн 17.1.13 дахь заалтад заасан гэрээний загвар болон 25.2 дахь хэсэгт заасан шатлан өсгөх хэлбэрээр нөхөн төлбөрийн хэмжээг тооцох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/635 тоот тушаалын хавсралтаар “Ус бохирдуулсны нөхөн төлбөрийг шатлан өсгөх хэлбэрээр ногдуулах журам”-ыг баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Батлагдсан журмыг үндэслэн 2023 онд 88 аж ахуйн нэгжид 1.38 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 2024 онд 85 аж ахуйн нэгжид 2.13 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 2025 онд 98 аж ахуйн нэгжид 2.7 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр ногдуулж, Татварын албанд хүргүүлэн ажилласан.
45	28.4. Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана;	Усны мэдээллийн нэгдсэн системээр ирүүлсэн хүсэлтүүдийг судлан Усны газар өмнөх оны дүгнэлт, гэрээ, зөвшөөрөлд хяналтыг тавьж тухай бүр хэлэлцүүлдэг. Эрчим хүчний зохицуулах хорооны Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нийт 53 ААНБ байдгаас хүн амын ус хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 40 ААНБ байна. Эдгээр байгууллагууд руу ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл авч ажиллах тухай 2025.04.22-ны өдрийн 01/217 дугаартай бичгээр чиглэл өгч ажилласан. Сав газрын захиргаад болон аймаг, нийслэлийн БОГ-аас гаргасан ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээнд хяналт тавин, зөвлөгөө өгч ажилласан. 2023 онд 209 аж ахуй нэгж, байгууллагын ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж, мэдээллийг салбараар, сав газрын захиргаа, аймаг, нийслэлээр нэгтгэн гаргасан. Ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан байдлаар төлбөр ногдуулсан усны хэмжээ 172.0 сая.м^3/жил, усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 121.6 тэрбум төгрөг. 2024 онд Усны газар, СГЗ, БОГ-аас 229 сая.м3 ус ашиглуулахаар дүгнэлт гаргаж зохих төлбөрийн хэмжээг ногдуулсан. 2025 онд СГЗ-аас нийт 163 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр ногдуулсан усны хэмжээ 1,2 сая.м^3/жил, урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр 305.7 сая төгрөг, аймаг, нийслэлийн БОГ-аас нийт 459 ус ашиглуулах дүгнэлт гаргаж, ногдуулсан усны хэмжээ 2.1 сая.м^3/жил урьдчилсан байдлаар ногдуулсан төлбөр 414.1 сая.төгрөг байна.
46	28.5. Энэ хуулийн 28.4-т заасан этгээд ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана.	
47	28.7. Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар дүгнэлт гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авна	Хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллага нь усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаар жил бүр ус ашиглуулах дүгнэлтээ гаргуулж, сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, гэрээ байгуулан хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 2023 онд 33, 2024 онд 26, 2025 онд 30 ус хангагч байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч бүрэн шийдвэрлэсэн.

48	30.1.1. Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх;	Ус ашиглуулах дүгнэлт, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан тохиолдолд Засгийн газрын 2018 оны 391 дугаар тогтоолоор батлагдсан “Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөр тооцох” журмын дагуу ус ашиглуулах гэрээ байгуулсан байгууллага болох Сав газрын захиргаа болон аймаг, нийслэлийн Байгаль орчны газраас төлбөрийг ногдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг. 2025 онд Галба Өөш-Долоодын говийн сав газар, Туул, Умард говийн гүвээт Халхын дундад талын сав газарт тус тус хамаарах " Монголын Алт МАК” ХХК, "Си Өү Эй Эл" ХХК, "Монцемент билдинг материалс" ХХК, "Монголиан коал клининг" ХХК, "Говь ресурс девелопмент" ХХК, “Эм Жи Жи И Си” ХХК-д ирүүлж ашигласан усанд тухайн журмаар төлбөр ногдуулан орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.
49	30.1.2. Хоногт 50 шоометрээс их ус ашиглагч Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.7-д заасны дагуу дотоод хяналтын цэг, техник хэрэгсэлтэй байх ба усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах;	2025 оны 01 дүгээр сараас эхлэн Ус ашиглуулах дүгнэлт бүрийн “Онцгой нөхцөл” хэсэгт тус заалтыг хэрэгжүүлэх шаардлагыг оруулан ажиллаж байна. 2025 оны байдлаар 308 дүгнэлт гаргуулсан бөгөөд 71 хувь нь усны менежертэй болсон байна.
50	30.1.4. Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах;	Ус ашиглуулах дүгнэлтийн “Онцгой нөхцөл” хэсэгт “Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах” шаардлагыг тусган байна. 2025 оны байдлаар нийт ус хэрэглэгч, ашиглагчид 4680 ш баталгаажуулсан тоолуур суурилуулж, усны хэрэглээгээ бүрэн хянаж байна.
51	30.1.5. Ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх;	Ус ашиглуулах дүгнэлтийн “Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө” хэсэгт Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх” гэсэн заалтыг тусган оруулсан, мөн дараа жилийн ус ашиглуулах дүгнэлтийг гаргахад урд оны ус ашиглал болон төлбөрийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилладаг. 2025 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрт 87.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт, ус бохирдуулсаны төлбөрт 7.5 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн байна.
52	30.6. Уул уурхайн олборлолтод ус ашиглах аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал баяжуулах усаа голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор дамжуулан авна.	Усны газраас гаргадаг ус ашиглуулах дүгнэлт бүрийн “Онцгой нөхцөл” хэсэгт хуулийн тус заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулахыг хориглоно, голын хамгаалалтын бүсэд хөрс хуулалт, олборлолт явуулахыг хориглоно” гэсэн шаардлагыг тусгаж, хяналт тавин ажиллаж байна.
53	31.1. Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө.	Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг усны баталгаажсан тоолууртай тохиолдолд тоолуурын заалт, тоолуургүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлтээр ногдуулсан хэмжээгээр усны төлбөрийг төлүүлэн ажиллаж байна. 2025 онд ус, рашааны нөөц ашигласны төлбөрт 87.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

---o0o---

УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт
1	4.6.Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журмыг энэ хуулийн 7.1-д заасныг үндэслэн бүс нутгийн хөгжлийн онцлогийг харгалзан Засгийн газар тогтоож болно.	Энэ хуулийн 4.1-д заасныг үндэслэн ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлж байна.
2	5.2.Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам, тооцоолох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулан Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2015 оны А-299/204 дугаар хамтарсан тушаалыг шинэчлэн боловсруулж, дахин Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын 2021 оны А/406/226 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар “Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам”, хоёрдугаар хавсралтаар “Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцоолох аргачлал”-ыг тус тус батлуулсан. Энэхүү журам, аргачлал нь ус бохирдуулсны төлбөр тооцох үндсэн эрх зүйн акт бөгөөд актуудыг үндэслэн Усны газар 2020 онд 24, 2021 онд 104, 2022 онд 125, 2023 онд 174, 2024 онд 178, 2025 онд 252 хаягдал усны дүгнэлт гаргасан, Сав газрын захиргаад 2020 онд 1907, 2021 онд 3518, 2022 онд 4160, 2023 онд 3868, 2024 онд 2072, 2025 онд 1424 хаягдал усны дүгнэлт гаргасан байна.
3	5.3.Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хаягдал усны дүгнэлт гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор татварын алба болон ус бохирдуулагчид хүргүүлнэ.	Усны газрын захиалгаар Монголын Мянганы Сорилтын сангийн санхүүжилтээр “Усны мэдээллийн нэгдсэн систем” буюу ewater.mn цахим системийг нэвтрүүлэхээр "Аствишн" ХХК"-ийг гүйцэтгэгчээр шалгаран 2022 оны 06 сараас хамтран ажиллаж, 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдөр ашиглалтад оруулсан. Цахим системийг нэвтрүүлснээр иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад үзүүлдэг үйлчилгээнүүд болох Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлт, Ус ашиглуулах дүгнэлт, Хаягдал усны дүгнэлт, Ус ашиглах гэрээ, Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ, Ус ашиглах эрхийн бичиг, Хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрлийн бичиг зэрэг 7 үйлчилгээг цахимжуулж, 2 дахин бага хугацаанд шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. Цахим систем нэвтэрснээр ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын усны барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний байршил, зориулалт, хүчин чадал, ажиллагааны түвшин /хэвийн ажиллагаатай эсэх/, сар, улирал, жилээр ашигласан ус, татан зайлуулсан хаягдал ус, дахин ашигласан усны хэмжээ, усны чанарын хяналт /унд ахуйд ашиглаж буй ус болон хүрээлэн буй орчинд нийлүүлж буй хаягдал ус нь стандартын шаардлага хангаж буй эсэх/ зэрэгт тогтмол хяналт тавих, шаардлагатай мэдээллийг цаг тухай бүр нэгтгэн гаргах, улмаар улсын

		хэмжээнд усны талаар төрөөс баримтлах бодлого шийдвэрт зөв гарцыг тусгах боломж бүрдсэн байна. Ус бохирдуулсны төлбөр тооцох, хаягдал усны дүгнэлт гаргах ажлыг цахимжуулснаар Хаягдал усны дүгнэлт гаргуулах хүсэлтийг 100% хүлээн авч, 2024 онд 147, 2025 онд 414 “Хаягдал усны дүгнэлт” гаргуулах хүсэлтийг ewater.mn цахим системээр хүлээн авч шийдвэрлэсэн байна. Ус бохирдуулагчдад Хаягдал усны дүгнэлтийг цахим системээр тоон гарын үсгээр баталгаажуулсны дараа, татаж авахаар тохируулсан бөгөөд шийдвэрлэгдсэн дүгнэлтийг нэгтгэн ажлын 3 хоногийн дотор Татварын алба болон Сав газрын захиргаанд цахимаар хүргүүлж байна.
4	6.2.Хоногт 50 шоометрээс бага, аюултай бохирдуулах бодис агуулаагүй хаягдал ус гаргадаг үйлдвэр, үйлчилгээний нэгжээс гарах хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээг үйлдвэр, үйлчилгээний салбар бүрээр усны хэрэглээний норм, хүчин чадал, ашиглалтын горимыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран тогтооно.	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2019 оны А-816/218 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээ”-г шинэчлэн батлагдсан “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024” стандарттай уялдуулан шинэчлэн боловсруулж, нийт 7 удаа холбогдох газруудаар хэлэлцүүлж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Хот, байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025.09.03-ны өдрийн А/705, А/205 хамтарсан тушаалаар батлуулж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7360 дугаарт бүртгүүлсэн.
5	7.1.Төлбөрийн хэмжээг хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээнд үндэслэн бүс нутгийн хөгжлийн онцлогийг харгалзан дараах хязгаарт багтаан Засгийн газар тогтоож болно:	Засгийн газрын 2019 оны 316 тогтоолын нэгдүгээр хавсралтаар жинлэгдэх бодис, органик бодис, эрдэс бодис, хүнд металл, аюултай бохирдуулах бодисын төлбөрийн хэмжээг батлуулан, хүчин төгөлдөр мөрдүүлж байна. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулийн шинэчилсэн найруулгаар Улсын зэрэглэлтэй, орон нутгийн зэрэглэлтэй хотын захирагч Ус бохирдуулсны төлбөрийн хэмжээг тогтоохоор заасан тул холбогдох төрийн захиргааны байгууллагыг мэргэжил аргазүйгээр ханган ажиллаж байна. Төлбөрийн хэмжээг тогтоох зохицуулалтыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хуульчилсан байна. Тус заалтын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийт 12 удаагийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 795 хүн хамруулсан. Үүнд: 2025.02.06-нд ММССангийн байранд, 2025.02.20-нд Орхон аймгийн Баян-Өндөр суманд, 2025.03.20-нд Усны газрын Хатантуул танхимд, 2025.03.27-нд ТЕГ-ын удирдах ажилтны зөвлөгөөнд, 2025.04.04-нд Дорноговь аймгийн Сайншанд суманд, 2025.05.26-нд Сүхбаатар аймгийн Баруун-Урт суманд, 2025.10.10-нд СГЗ-дын мэргэжилтнүүдэд, 2025.10.15-нд Дархан-Уул аймгийн Дархан суманд, 2025.10.22, 23-ны өдөр 21 сав газрын ус ашиглагч нарт, 2025.11.20-нд Нийслэлийн Татварын албаны байцаагч нарт тус тус танхим болон онлайнаар, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, эрх зүйн зохицуулалт, шинэчлэн

		батлагдсан хууль тогтоомжийг танилцуулах сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.
6	7.3.Төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт-шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50 хувийг хотын дэд бүтцийн санд төвлөрүүлж, цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар үйлчилгээнд зарцуулна.	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны захиалгаар Монголын Мянганы Сорилтын сангийн санхүүжилтээр Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах Зөвлөх үйлчилгээний багийг гэрээгээр ажиллуулж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт, өөрчлөлтөөр нийслэл Улаанбаатар хот, улсын зэрэглэлтэй хот, орон нутгийн зэрэглэлтэй хотын Дэд бүтцийн санд ус бохирдуулсны төлбөрийн орлогын 50 хувийг төвлөрүүлж, хот, суурин газрын цэвэрлэх байгууламжийн шинэчлэл, засвар, үйлчилгээнд зарцуулахаар хуульчилсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Хууль хэрэгжсэнээс хойш Улсын төсөвт ус бохирдуулсны төлбөрт 2020 онд 46.3 сая төгрөг, 2021 онд 478.7 сая төгрөг, 2022 онд 2.34 тэрбум төгрөг, 2023 онд 2.11 тэрбум төгрөг, 2024 онд 2.14 тэрбум төгрөг, 2025 онд 7.53 тэрбум төгрөг төвлөрсөн байна.
7	8.1.1.хаягдал усыг усны чанарын стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэсэн хэмжээгээр;	Усны чанарын стандарт гэдэг нь “Усан орчны чанар. Ерөнхий шаардлага MNS 4586:2024” стандарт бөгөөд энэ нь байгалийн усны дэвсгэр агууламжийг илэрхийлдэг. Ус бохирдуулагчид хаягдал усаа энэ стандартын хэмжээнд хүртэл цэвэрлэж чадахгүй байгаа тул тус заалтаар төлбөрөөс чөлөөлөх зохицуулалт хийгдээгүй байна.
8	8.1.2.хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн үйлдвэр, үйлчилгээнд ашигласан бол дахин ашигласан хэмжээгээр.	Энэ заалтын дагуу уул уурхай, эрчим хүчний салбарын төсөл хэрэгжүүлэгчид хаягдлын сан болон үнсэн санд нийлүүлсэн усаа механик аргаар тунгаан цэвэрлэж, эргүүлэн үйлдвэрлэлд ашигласан хэмжээгээр төлбөрөөс чөлөөлөгдөж байна. Үүнд: 2020 онд нийт хаягдал усны 78.7%, 2021 онд 74%, 2022 онд 79.04%, 2023 онд 80.56%, 2024 онд 83.27%, 2025 онд 82.11%-ийг тус тус 100% чөлөөлсөн. Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпорац хооронд байгуулсан Мянганы сорилтын компакт гэрээний хүрээнд баригдсан “Хаягдал усыг дахин боловсруулах үйлдвэр” нь хоногт 50 мянган шоометр усыг гүн цэвэрлэж, нийт цэвэрлэсэн усны 65 хувийг Дулааны III, IV цахилгаан станцад нийлүүлэхээр шугам сүлжээ, барилга байгууламжийн ажил 100% хийгдсэн бөгөөд үнэ тариф батлахаар ажиллаж байна. Мөн “М Си Эс кокакола” ХХК-ийн үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламжид цэвэрлэсэн усыг Амгалан дулааны станц дулаан үйлдвэрлэх үйл ажиллагаандаа дахин ашиглаж эхлээд байна.
9	8.1.3.хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдсон бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар.	Энэ заалтын зохицуулалтаар нэг ч иргэн, аж ахуйн нэгж төлбөрөөс чөлөөлөгдөөгүй. Улаанбаатар хотын шинэ Төв цэвэрлэх байгууламж ашиглалтад орохтой холбогдуулан шинэчлэн батлуулсан “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 6561:2024” стандартын бохирдуулагч ангиллын 12 салбарын 70 үйлдвэрийг урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах

		шаардлага хүргүүлсэн бөгөөд цэвэрлэх байгууламж барьж, Улсын комисст хүлээлгэн өгсөн аж ахуйн нэгжүүд 2026 оны нэгдүгээр улирлаас эхлэн хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа нь тогтоогдвол төлбөрөөс чөлөөлөгдөнө. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Улаанбаатар хотын 70 үйлдвэрийг урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах ажлыг эрчимжүүлэхээр Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 2-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл, 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 26 дугаар тэмдэглэл, 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэл гаргуулж, холбогдох яам, агентлагийн сайд, дарга нарт үүрэгжүүлсэн. 70 үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламж барих талаар мэдээлэл өгөх сургалтыг 2025.06.26-ны өдөр, Барилгын хөгжлийн төвд зохион байгуулсан. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 2025 оны 02/1229 тоот "Үйлдвэрийн урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулах тухай", "Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар" ОНӨААТҮГ-ын 2025 оны 8/3076 тоот "6561:2024 стандартын шаардлага хангаагүй хаягдал ус нийлүүлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын ус хангамжийг хязгаарлах тухай" бичгүүдийг мөн ажлын хэсгээс санал болгосны дагуу хүргүүлсэн. 2025.12.31-ний байдлаар Очир дагинас ХХК, Говь ХК, Жүр үр ХХК, Газар шим ХХК, Витсамо фрут жүүс ХХК, Дунь Яань ХХК цэвэрлэх байгууламж шинээр барьсан, АПУ ХК цэвэрлэх байгууламжаа 2025.06.10-нд шав тавьж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн, ТЭСО ХХК нь охин компани болох МИЛКО ХХК, Айсмарк ХХК-тай хамтран дундын цэвэрлэх байгууламж барьж байгаа бөгөөд цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил 80%-тай байна. Бусад үйлдвэрүүд судалж байгаа, барих газар талбай байхгүй, хуучин цэвэрлэх байгууламжаа шинэчилж байгаа, зураг төсөл хийлгэж байна. 2025 оны сүүлийн хагас жилд Хаанхүнс ХХК, Милко ХХК, Витафит инвест ХХК, Витафит милк ХХК, Айсмарк ХХК цэвэрлэх байгууламж барьж эхэлсэн. 45 үйлдвэр УБ хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-тай 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө цэвэрлэх байгууламж барих гэрээ байгуулсан байна.
10	8.2.Хот, суурин газраас бусад газар оршин суугаа бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчийг төлбөрөөс чөлөөлнө.	Энэ заалтын зохицуулалтаар нэг ч иргэн, аж ахуйн нэгж төлбөрөөс чөлөөлөгдөөгүй. Иргэн, аж ахуй нэгж аль нь болохыг тодорхой заагаагүй, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4.1 дэх хэсэгт зааснаар өрхийн зориулалтаар мал аж ахуй эрхлэх бол чөлөөлөгдөхөөр байна. Энэ заалтыг тодорхой болгох. Хэрэгжих боломжгүй байна.
11	8.3.Хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг болон төсвөөс санхүүждэг эрүүл мэнд, боловсрол, халамжийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг хаягдал усны стандарт, тогтоосон норм норматывыг хангаж ажилласан тохиолдолд төлбөрөөс хөнгөлж болно.	Ус бохирдуулсны төлбөрөөс 2023 онд эрүүл мэндийн салбарын 132 байгууллагаас 63.38 сая төгрөг, боловсролын салбарын 476 байгууллагаас 24.4 сая төгрөг, хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг 29 байгууллагаас 333.48 сая төгрөг, 2024 онд эрүүл мэндийн салбарын 146 байгууллагаас 69.86 сая төгрөг, боловсролын салбарын 533 байгууллагаас 29.64 сая төгрөг, хот,

		суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг 30 байгууллагаас 301.9 сая төгрөг, 2025 онд эрүүл мэндийн салбарын 83 байгууллагаас 36.73 сая төгрөг, боловсролын салбарын 301 байгууллагаас 20.3 сая төгрөг, хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг 21 байгууллагаас 217.5 сая төгрөгийг тус тус хөнгөлж, тайланг нэгтгэн Татварын албанд хүргүүлсэн.
12	8.4.Энэ хуулийн 8.3-т заасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг заасан журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2019 оны 316 тогтоолын хоёрдугаар хавсралтаар “Ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээ тогтоох журам” баталсан. 2023 онд эрүүл мэндийн салбарын 132 байгууллагаас 63.38 сая төгрөг, боловсролын салбарын 476 байгууллагаас 24.4 сая төгрөг, хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг 29 байгууллагаас 333.48 сая төгрөг, 2024 онд эрүүл мэндийн салбарын 146 байгууллагаас 69.86 сая төгрөг, боловсролын салбарын 533 байгууллагаас 29.64 сая төгрөг, хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг 30 байгууллагаас 301.9 сая төгрөг, 2025 онд эрүүл мэндийн салбарын 83 байгууллагаас 36.73 сая төгрөг, боловсролын салбарын 301 байгууллагаас 20.3 сая төгрөг, хот, суурин газрын ахуйн бохир усыг цэвэрлэдэг 21 байгууллагаас 217.5 сая төгрөгийг тус тус хөнгөлж, тайланг нэгтгэн Татварын албанд хүргүүлсэн.
13	9.1.Төлбөр төлөгч нь тухайн улиралд байгаль орчинд шууд хаясан болон ариутгах татуургын байгууламжид нийлүүлсэн хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор харьяалах татварын албанд хүргүүлнэ.	Төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд холбогдсон ус бохирдуулагчдын мэдээллийг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4.4 дэх хэсэгт заасан үзүүлэлтээр хангагч байгууллагаас улирал бүр авч, Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээгээр ус бохирдуулсны төлбөрийг тооцон Татварын албанд дараа улирлын эхний сарын 15-ны дотор цахимаар хүргүүлж байна. Хүрээлэн буй орчинд хаягдал ус нийлүүлдэг ус бохирдуулагчийн төлбөрийг ewater.mn цахим системээр хүлээн авч, ногдуулан Татварын албанд ажлын 3 хоногийн дотор хүргүүлж байна.
14	9.3.Төлбөрийн тайлангийн маягтыг татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.	Татварын ерөнхий газрын даргын 2022 оны А/50 дугаар тушаалаар "Ус бохирдуулсны төлбөрийн тайлан"-гийн маягт /ТТ-25/-ыг 1 дүгээр хавсралтаар, "Хаягдал усанд агуулагдах жинлэгдэх бодис, органик бодис, эрдэст бодис, хүнд металл бодис, аюултай бохирдуулах бодисын хэмжээгээр ногдуулсан төлбөрийн мэдээ" /ХМ-25(1)/-г 2 дугаар хавсралтаар, "Хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын жишиг хэмжээгээр ногдуулсан төлбөрийн мэдээ" /ХМ-25(2)/-г 3 дугаар хавсралтаар, нөхөх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн батлуулж, Татварын ерөнхий газартай хамтран Ус бохирдуулсны төлбөрийг тайлагнах тооцооллыг эксел программ дээр боловсруулан, etax.mta.mn цахим системд нэвтрүүлэх загварыг боловсруулан, Татварын албаны байцаагч нарт сургалтыг зохион байгуулсан.

---o0o---

**ГОЛ, МӨРНИЙ УРСАЦ БҮРЭЛДЭХ ЭХ, УСНЫ САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС,
ОЙН САН БҮХИЙ ГАЗАРТ АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХЫГ ХОРИГЛОХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

№	Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт
1	4.1.Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглоно.	Гол мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалтай - ашиглалтын 59 зөвшөөрөл, - хайгуулын 5 тусгай зөвшөөрөл, Ойн сан бүхий газрын хилийн заагтай давхцалтай - ашиглалтын 154 зөвшөөрөл, - хайгуулын 14 зөвшөөрөл, Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүстэй давхцалтай - ашиглалтын 222 зөвшөөрөл, хайгуулын 38 зөвшөөрөл давхцалтай байгаа бөгөөд үйл ажиллагааг нь хязгаарласан.
2	4.2.Энэ хуулийн 4.1 дэх хэсэг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарахгүй.	УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолоор баталсан стратегийн орд бүхий газрууд тус хуулийн үйлчлэлд хамраарахгүй.
3	4.3.Энэ хуулийн 4.1-д заасан газрын хилийн заагийг Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 2011 оны 174 дүгээр тогтоолоор “Ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газрын хилийн заагийг хэсэгчлэн тогтоосон” Засгийн газрын 2012 оны 194 дүгээр тогтоолоор Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийг 1 дүгээр, Усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн хилийн заагийг 2 дугаар, Ойн сан бүхий газрын хилийн заагийг 3 дугаар хавсралтаар баталсан. - Гол мөрний урсац бүрэлдэх эх /144157,6 км2/ буюу нийт газар нутгийн 9,1% /6958ш цэг/ - Ойн сан бүхий газар /185924,1 км2/ буюу нийт газар нутгийн 11,8% /3,5 сая цэг/ - Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс /102602.6 км2/ буюу нийт газар нутгийн 6,5 % тус тус эзэлж байна. /2,7 сая цэг/ /2010 онд 314 сумдын засаг даргын захирамжаар тогтоосон солбицлыг үндэслэж тогтоосон./ Засгийн газрын 2015 оны 289 дүгээр тогтоолоор Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг 200 метрээр шинэчлэн тогтоосон. Энэ нь 6,1 сая га буюу нийт газар нутгийн 4,4 % тус тус эзэлж байна.
4	4.4.Энэ хуулийн 4.3-т заасан хилийн заагийн гадна үйл ажиллагаа эрхэлж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хөрөнгөөр байгаль орчны нөхөн сэргээлт хийж, таримал ой, хиймэл нуур, усан сан байгуулсан бол энэхүү хуулийн үйлчлэлд хамаарахгүй.	Засгийн газрын 2015 оны 120 дугаар тогтоолын дагуу Таван талт гэрээ байгуулсан. Энэхүү гэрээ нь Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Тусгай зөвшөөрлийг цуцлах, олборлолт явуулж эхэлсэн талбайд нөхөн сэргээлт хийлгэх, хяналт тавих зорилгоор усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байсан компаниудтай байгуулсан. 2015 онд 5-лсан буюу таван талт гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд байгаль орныг нөхөн сэргээх үүрэг даалгавар өгсөн бөгөөд тухайн гэрээ байгуулсан тусгай зөвшөөрөл

		эзэмшигч байгууллагууд жил бүр нөхөн сэргээлт хийсэн талбайг тухайн орон нутагт актаар хүлээлгэн өгч жил бүр гэрээг дүгнэж ажилласан.
5	4.5.Энэ хуулийн 4.1-д заасан газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй.	- Гол мөрний урсац бүрэлдэх эх /144157,6 км2/ буюу нийт газар нутгийн 9,1% - Ойн сан бүхий газар /185924,1 км2/ буюу нийт газар нутгийн 11,8% - Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг 200 метрээр шинэчлэн тогтоосон. Энэ нь 6,1 сая га буюу нийт газар нутгийн 4,4 % тус тус эзэлж байна. Тус талбайнуудад 2012 оноос хойш шинээр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарласан.
6	4.6.Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно.	Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолоор "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн олговор олгох журам"-ыг батлсан.
7	5.1.Энэ хуулийн 4.6-д заасны дагуу ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцалсан нь тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээс чөлөөлөхгүй.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн дагаж мөрдсөнөөс өмнө үйл ажиллагаа явуулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид Таван талт гэрээ байгуулан нөхөн сэргээлтийн ажлыг хийн гэрээг жил бүр дүгнэдэг.
8	5.2.Байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг орон нутгийн удирдлага болон нутгийн иргэдийн олон нийтийн хяналт дор 2 хүртэл жилийн хугацаанд хийж дуусгана.	2015 онд байгуулагдсан энэхүү гэрээний дагуу усны хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байсан компаниуд нөхөн сэргээлт хийх үүрэг хүлээсэн байдаг. Тухайн таван тал гэрээ нь Байгаль орчны төрийн захиргааны төв байгууллага, Ашигт малтмалын газар, мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Орон нутгийн захиргаа, тусгай зөвшөөрөл эзэмшигч гэсэн 5 байгууллага нь жил бүр гэрээг дүгнэдэг.
9	5.3.Энэ хуулийн 5.2-т заасан олон нийтийн хяналтыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр байгаль орчныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагуудад гэрээний үндсэн дээр хариуцуулж болно.	ИТХ-ын шийдвэрээр байгаль орныг хамгаалах зорилго, чиглэл бүхий төрийн бус байгууллагад хариуцуулаагүй. Байгаль орныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх Таван талт гэрээ буюу Гол, мөрний урсац бүрэлдэх эхийн бүсэд олгосон тусгай зөвшөөрлийг цуцлах, усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсэд олборлолт явуулж эхэлсэн, тусгай зөвшөөрөл бүхий талбайд холбогдох арга хэмжээ авах, нөхөн сэргээлт хийлгэх журмаар зохицуулдаг.

---o0o---